



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ
ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧ НАРТ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВ

Нам Ян Жугийн гудамж 32/1,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13335
Утас: 45 39 94, Факс: (976-11) 45 86 99,
Цахим шуудан: info@nccd.gov.mn,
Цахим хуудас: www.nccd.gov.mn

2026.08.26 № 3-3/1471

танай _____-ны № _____-т

Үнийн санал авах тухай

Манай төв аймаг, орон нутгаас халдварын эрсдэлтэй биологийн дээж, сорьцыг аюулгүй тээвэрлэх, тээвэрлэлтийн горим алдагдуулахгүй байх шаардлагад нийцсэн сорьц тээвэрлэх савыг иж бүрдлээр нь худалдан авахаар төлөвлөж байна.

Иймд хавсралт дахь техникийн шаардлагыг хангасан “Сорьц зөөвөрлөх сав” нийт 21 ширхгийг нийлүүлэх эм, эмнэлгийн хэрэгсэл импортлогч компаниуд техникийн тодорхойлолтод нийцүүлэн, үнийн санал, ханган нийлүүлэх хугацааны мэдээллийг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалтын дагуу 2026 оны 09 дугаар сарын 04-ний дотор ирүүлнэ үү.

Саналыг байгууллагын албан тоотоор баталгаажуулж холбогдох материалын бүрдэл (улсын бүртгэлийн гэрчилгээ, ижил төстэй ажлын гэрээ, мэдээлэл)-ийг ханган tender@nccd.gov.mn хаягаар ирүүлнэ үү.

ЗАХИРАЛ



С.ЭНХБОЛД

ХАЛДВАРТАЙ СОРЬЦТОЙ ТЭЭВЭРЛЭХ БИО АЮУЛГҮЙН
ХАЙРЦГИЙН ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

№	Үзүүлэлт	Техникийн шаардлага
1	Төрөл	Халдвартай сорьц тээвэрлэх зориулалттай, 3 давхар савлагааны зарчимд нийцсэн.
2	Стандарт	UN 3373 (Category B) стандартын шаардлага хангасан.
3	Дотоод багтаамж	6-12 литр
4	Гадна талын хэмжээ	400 x 250 x 300мм (+/- 20мм-ийн зөрүү байж болно.)
5	Материал	Гадна тал: Цохилтод тэсвэртэй өндөр нягтралтай полиэтилен (HDPE) Дотор тал: Чийг болон химийн бодист тэсвэртэй, арчиж ариутгахад хялбар ABS хуванцар
6	Температур хянагч	Гадна талдаа дижитал LCD дэлгэцтэй, доторт талдаа температур бүртгэгч (USB data logger) төхөөрөмжтэй
7	Дулаан баригч	+2°C-оос +8°C хэмийг 24-48 цаг тогтвортой хадгалдаг байх (PU хөөсөнцөр дулаалгатай)
8	Аюулгүйн цоож	Санамсаргүй байдлаар нээгдэхээс сэргийлсэн, бат бөх түгжээ, цоожлох боломжтой механик системтэй.
9	Тэмдэглэгээ	Олон улсын стандартын "Биологийн аюултай" (Biohazard) тэмдэгтэй. Босоо байрлалыг заагч суман тэмдэгтэй.
10	Дагалдах хэрэгсэл	Зориулалтын хөлдөөх хэрэгсэл (ice pack), хоёрдогч сорьц тогтоогч тавиур эсвэл ууттай.
11	Тоо ширхэг	21 ширхэг